



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2026.06.02

Улаанбаатар хот

Контентийн сэдэв: Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх;

Зорилго: Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн ач холбогдлыг энгийн ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар иргэд, даатгуулагчид, ажил олгогчдод сурталчлах контент боловсруулж, түгээхэд оршино.

Нэмэлт мэдээлэл, бүрдүүлэх материал:

Үнийн санал ирүүлэх байгууллага	-Контент бүтээгч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн;
Гүйцэтгэх ажил	-Батлагдсан ажлын даалгаврын дагуу видео контент, социал контент, хэвлэмэл эх бэлтгэлийг чанартай хийж гүйцэтгэн, хугацаанд нь хүлээлгэн өгөх;
Гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 1 сарын дотор;
Бүрдүүлэх материал	Үнийн санал ирүүлж буй байгууллага нь дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ. • Байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээ; • Ажил гүйцэтгэх үнийн санал; • Энэ чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын туршлагын талаарх танилцуулга.

Холбогдох материалыг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 17 цагаас өмнө доорх хаягаар болон undeg@ndaatgal.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 13/1, Нийгмийн даатгалын ерөнхий газар;

Утасны дугаар: 328030-304;

---///---

БАТЛАВ.
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Б.БАТЖАРГАЛ
2026 оны 06 дугаар сарын

АЖЛЫН ДААЛГАВАР

Зорилго: Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн ач холбогдлыг энгийн ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар иргэд, даатгуулагчид, ажил олгогчдод сурталчлах контент боловсруулж, түгээхэд оршино.

Арга хэмжээний нэр: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөө”-ний 1.5-д тусгагдсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх”;

Хөрөнгийн эх үүсвэр: Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын 2026 оны төсөв;

Төсөвт өртөг: 20,000,000 (хорин сая) төгрөг;

Ажлын даалгавар: Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн ач холбогдлыг энгийн ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар иргэд, даатгуулагчид, ажил олгогчдод сурталчлах контентыг дараах байдлаар боловсруулах;

№	Контентын агуулга	Контентын төрөл	тоо ширхэг	Тавигдах шаардлага
Видео контент				
1	• Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, түүний ач холбогдол	1-2 минутын мэдээллийн видео	3 ширхэг	• Мэргэжлийн зураг авалт, эвлүүлэг хийх; • Орчин үеийн загвар дизайн ашиглах; • Контентод ашиглагдаж буй дуу, бичвэр нь Монгол хэлний дүрэмд нийцсэн найруулгатай (хадмал бичвэртэй) хуулийн нэр томьёо алдаагүй, иргэдэд ойлгомжтой энгийн
2	• Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж	30-60 секундын богино видео (Reel)	3 ширхэг	

				хэллэгээр илэрхийлсэн байх; • Нийгмийн сүлжээ болон телевизийн хэрэглээнд тохирсон форматтай байх; • Бүх видео засварлах боломжтой эх файлыг хүлээлгэн өгөх;
Сошиал контент				
1	• Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, түүний ач холбогдол • Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж	Facebook пост	10 ширхэг	• Мэргэжлийн зураг авалт, график эвлүүлэг, дуу оруулалттай байх; • Орчин үеийн загвар дизайн ашиглах; • Контентод ашиглагдаж буй дуу, бичвэр нь Монгол хэлний дүрэмд нийцсэн найруулгатай (хадмал бичвэртэй) хуулийн нэр томьёо алдаагүй, иргэдэд ойлгомжтой энгийн хэллэгээр илэрхийлсэн байх; • Нийгмийн сүлжээний хэрэглээнд тохирсон форматтай байх; • Бүх пост, контент засварлах боломжтой байх;
2		Story контент	5 ширхэг	
Хэвлэмэл эх бэлтгэл				
1	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	Постер	2 ширхэг	• Мэргэжлийн график эх бэлтгэл; • Орчин үеийн дизайн ашиглах; • Дахин засварлах боломжтой байх.
		Баннер	2 ширхэг	

Хийж гүйцэтгэх хугацаа: Гэрээ байгуулж, шаардлагатай мэдээллийг хүлээн авснаас хойш 1 сарын дотор.